



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ӨРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжжээ ахэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

.....*Талмантөр*..... аймгийн
Эрүүл мэндийн газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

..... аймэг
..... сум..... баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил өргө зүйн дэмжлэг үзүүлэх, агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө харууцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд шатны бусад байгууллагаас гаргасан бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хянах, тайлагнах.
2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн бодлого чиглэлээр хангах.
3. Санхүүгийн болон хүний нөөц бодлого, ам хангамж, тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах.
4. Байгууллагын төсвийн хөрөнгө, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, хяналт тавих.
5. Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г, Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагаандаа хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллах 2. Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, норм, норматив, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх. 3. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сүм дундын эмнэлэг, сүм, өрхийн эрүүл мэндийн төв, багийн их, бага эмчийн салбар зэрэг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн 	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Холбогдох байгууллагуудыг хуульд нийцсэн бодлого удирдамжаар хангасан байна.</p>	<p>Ш</p> <p>Х</p> <p>Ш</p>



	<p>байгууллагуудыг мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах</p> <p>4. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар үзүүлэх тусламж, үйлчилгээний бодлогыг тодорхойлох, түншлэл болон хамтын ажиллагааг дэмжих замаар улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой харилцааг бий болгох</p> <p>5. Нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг хянан шалгах, зааварлах, мэргэжлийн зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих.</p> <p>6. Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх.</p> <p>7. Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийн байдлыг хянаж, тайлагнаж.</p> <p>8. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Улсын болон хувийн байгууллагын харьцааг хуульд нийцсэн байна.</p> <p>Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангасан байна.</p> <p>Гадаад хамтын ажиллагааны дунд дээшилтэд арга барил нэвтэрсэн байна.</p> <p>Хууль тогтоомжид нийцсэн арга зүйгээр хангасан байна</p>	<p>Т</p> <p>Х</p> <p>Г</p> <p>Х</p> <p>Х, Г</p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах, үр дүнг тайлагнаж.</p> <p>2. Аймаг, сум, сум дунд, өрхийн болон хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл</p>	<p>Эрүүл мэндийн үйлчилгээний шуурхай байдлыг хангасан байна.</p>	<p>Х</p>



	<p>хандамжийг нэмэгдүүлэх, эмнэлзүйн стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах</p> <p>3. Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзэлг шинжилгээ хийж, зохиолон тохиолдож буй өвчин эмгэгийг илрүүлэн эмчлэх шат дараатай арга хэмжээг удирдан зохион байгуулах</p> <p>4. Нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдээс хүн амд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын зорилт чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн удирдлагаар хангах.</p> <p>5. Эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээний асуудлыг нэгтгэн зохион байгуулах, эм, эмнэлгийн зэрэгслийн хангамжийн асуудлыг зохион байгуулах, харьяа эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах, мэргэжлийн удирдлагаар хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг шат дараатай өвч хэрэгжүүлэх</p> <p>6. Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд, орон нутгийн удирдлагыг мэргэжил, арга зүйгээр хангах.</p> <p>7. Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах талаар төрийн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, эх хүүхдийн эндэгдлийг тууштай бууруулах.</p> <p>8. Нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай</p>	<p>Хуульд нийцсэн арга зүйгээр хангасан байна</p> <p>Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн байна.</p> <p>Үйлчилгээний судалгааны дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ өгч, үйлчилгээний чанарт ажиг гарсан байна.</p> <p>Харьяа байгууллагуудыг үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах арга хэмжээ авсан байх</p> <p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчлөлөөс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийг арга зүйгээр хангах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, өвчлөлүүд буурсан байна</p>	<p>Ш</p> <p>Г, Ш</p> <p>Х, Ш</p> <p>Г, Ш, Х</p> <p>Х, Ш</p> <p>Х</p> <p>Х, Ш</p>
--	---	---	--



	<p>хамтран зохион явуулах, өөчин үүсгэж буй халгаат хүчин зүйлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж хэрэгжүүлэх.</p> <p>9. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг аж ахуйн нэгж байгууллага, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах.</p>		Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Засаг дарга зохио хуулийн заалтын дагуу эрхээ Эрүүл мэндийн газрын даргад шилжүүлсэн тохиолдолд аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга, Зоонолын өвчин судлалын төвийн дарга нартай гэрээ байгуулах.</p> <p>2. Харьга эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнхалт гарган холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, үйл ажиллагаатай нь холбоотой эргэх мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.</p> <p>3. Харьга нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, түргэн тусламжийн авто машины ашиглалт, засвар үйлчилгээ, нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулах.</p> <p>4. Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стратеги, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвө, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулах.</p>	<p>Гэрээ хуульд нийцсэн байна.</p> <p>Хяналт шинжилгээ үнэлгээг хууль тогтоомжийн дагуу хийж, мэдээ мэдээллээр хангасан байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагыг ажиллах нөхцөлөөр бүрэн хангасан байна.</p> <p>Хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж, тайлагнасан байна.</p>	Х, Ш



	<p>5. Амналгийн мэргэжилтний хэрэгцээг тодорхойлж, төлөвлөлт хийх, амналгийн мэргэжилтний үр чадварыг сайжруулах, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах.</p> <p>6. Амналгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.</p> <p>7. Эрүүл мэндийн байгууллагуудад гарсан шинэ бүтээл, дэвшилтэт технологийд дүгнэлт гаргах, санал өгөх.</p> <p>8. Эрүүл мэндийн байгууллагуудын тэргүүний ажилтнуудыг шагнаж урамшуулах, аймагын болон төр засгийн дээд байгууллагын шагналд тодорхойлох.</p> <p>9. Эмч, амналгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг судлан, шийдвэрлэх боломжит шийдлүүдийг зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p>	<p>Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, үр чадварыг нэмэгдүүлэх талаар өмч хэрэгжүүлсэн байна.</p> <p>Ёс зүйн зөрчил гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авсан байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар бодит ажил хийсэн байна.</p> <p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажил хийсэн байна.</p>	<p>Х, Г</p> <p>Х</p> <p>Ш</p> <p>Х, Ш</p>
<p>4 дүгээр зорилтын хүрээнд</p>	<p>1. Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү, бусад нөөцийн талаар санал, төсвийн төсөл боловсруулж, батлуулах.</p> <p>2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дэмжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах.</p> <p>3. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшлэгчид хяналт тавьж балансад байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж ашиглах.</p> <p>4. Төсвийн болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг үр ашгтай зарцуулж, хяналт тавьж ажиллах.</p>	<p>Хууль тогтоомжид зассны дагуу төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Г, Х, Ш</p> <p>Г, Х</p> <p>Х</p> <p>Х</p>



	<p>5. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагналтад хяналт тавих.</p> <p>6. Төсөв санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;</p>		<p>Х</p> <p>Х</p>
5 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулах, хэрэгжилтийг хангах зэсгийг зохион байгуулах, тайлагнах, дүгнүүлэх</p> <p>2. Байгууллагын албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг соёлтой шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>3. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх.</p> <p>4. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх.</p> <p>5. Гадаадын ижил, төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, дэвшилтэд техник, технологийг ажилдаа нэвтрүүлэх арга хэмжээ авах</p> <p>6. Албан хэрэг хөтлөлт, архааны үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, стандартыг хэрэгжүүлэх.</p> <p>7. Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>8. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургах чадваржуулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна</p> <p>Байгууллагын болон мэргэжилтнүүдийн чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.</p> <p>Хүний нөөцийн бодлогын асуудал хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>Стандартыг мөрдүүлсэн байна. Өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.</p> <p>Сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр хэрэгжсэн байна</p> <p>Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.</p>	<p>Х, Ш</p> <p>Г, Х</p> <p>Г, Ш</p> <p>Г, Х</p> <p>Х</p> <p>Х, Ш</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p>



	9. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх		
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Эрүүл мэнд, хүний их эмч, нийгмийн эрүүл мэнд.		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдаж төгссөн байх		
Тураллага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дээш түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх		
Үр чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> -байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах шаардлага тавьж чаддаг байх; -удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оногтой тэнцвэртэй хуваарилах, үндэрдэх; -үйл ажиллагаан дахь эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; -албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; -албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, хуульд нийцсэн заавар чиглэл өгөх; -үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; -бусад. 	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> -судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах; -тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх; -судалгааны үр дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах; -бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - хууль тогтоомжид нийцсэн, оногтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах; -тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; -албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; -бусад. 	
	Мөнгөйлөх	<ul style="list-style-type: none"> -ёс зүйн хэм хэмжээг сахих, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх; -саналэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; -байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; -эливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгах; -хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; -бусад. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -албан бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөх; -мэдээллийг шуурхай хүргэх, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх; 	



-багийн ажлын амжилтыг уналах, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Аймгийн Засаг дарга

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <p>Ахлах мэргэжилтэн Мэргэжилтэн Төрийн үйлчилгээний албан хаагч</p> <p>Нийт ____ /тоо/</p>	<p>Бусад харилцах субъект:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн яамны холбогдох нэгжийн дарга, албан хаагч, - Эрүүл мэндийн хөгжлийн төв - I, II, III -дагч шатлалын эмнэлгүүд - Аймгийн Засаг даргын орлогч, - Аймгийн Засаг даргын Тамгын газар - Төрийн болон төрийн бус байгууллага - Иргэн, хуулийн этгээд
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан;	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл өгссөн байгууллагын шийдвэр;
--	--

<p>Албан тушаал</p> <p>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙТМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА</p> <p><i>Т. Валжаргал</i></p> <p>(Гарын үсэг) (Эцэглэхийн нэр, өөрийн нэр)</p> <p>2019 оны 09 дугаар сарын 16-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр:</p> <p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p>Шийдвэрийн өгсөө: 19.09.13</p> <p>Дугаар: 63</p>
--	--

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

<p>Байгууллагын нэр:</p> <p>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</p> <p>Шийдвэрийн өгсөө: 2019.09.27</p> <p>Дугаар: 11500</p> <p>(тамга/тамдэг)</p> <p>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА</p> <p><i>Т. Валжаргал</i></p> <p>(Гарын үсэг) (Эцэглэхийн нэр, өөрийн нэр)</p> <p>2019 оны 09 дугаар сарын 27-ны өдөр</p>	
--	---